Товьёг



| Д/д | Товч утга | Хуудасны тоо | Хуудасны дугаар |
|---|---|---|---|
| 1 | Монгол улсын хууль | 2 | 2-3 |
| 2 | Засгийн газрын тогтоол | 4 | 3-6 |
| 3 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 1 | 6-7 |
| 4 | ХНХ-ын сайдын тушаал | 4 | 7-10 |
| 5 | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол | 2 | 11-12 |
| 6 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал | 5 | 12-16 |

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАРТ
ХЯНАЛТАД АВСАН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
2024 оны хагас жил

| **Д/д** | **Зүйл заалтын дугаар** | **Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга** | **Хэрэгжилтийн явц** | **Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)** | **Тасарсан болон удааширч байгаа шалтгаан** |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Салбар чиглэл | | | | | |
| 1. Монгол улсын хууль | | | | | |
| 1 | | Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай 2023.04.21 | Орхон аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран 9 чиглэлд явууллын үйлчилгээ үзүүлж, 2 удаа Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж хуулийг сурталчлан ажиллаж 111 иргэд, даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн. Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутган төлөхийг зөвшөөрч, хүсэлт гаргасан иргэд байхгүй байна. | | |
| 2 | | Нийгмийн даатгалын Ерөнхий хууль 2023.07.07 | 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн УИХ-ын чуулганаар шинэчлэгдсэн батлагдсан Нийгмийн даатгалын Ерөнхий хуулийн танилцуулах сурталчлах ажлыг 2023 оны 10,11,12 дугаар сар Орхон аймагт хийж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэжүүлэн ажиллаж байна. | | |
| 3 | | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль 2023.07.07 | 2024 онд нийгмийн даатгалын салбар мэдээлэл, тооцооллын шинэ систем нэвтрүүлэн иргэд даатгуулагч тэтгэмж авах хүсэлтээ 78 хувь цахимаар илгээж, бодож | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | олгосон. Үлдсэн 5846 даатгуулагч биечлэн ирж үйлчлүүлсэн байна. | | |
| 4 | | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль 2023.07.07 | 2024 оны тайлант үед аймгийн хэмжээд дундаж тэтгэврийн дүн 921.7 мянган төгрөг байна. Энэ үзүүлэлт нь өмнө оны дундаж 853.1 мянган төгрөгөөс бага зэрэг буюу 7.9 хувиар өссөн байна. Баян-өндөр сум, Жаргалант сумуудаас 2025-2026 онуудад тэтгэврийн насанд хүрч байгаа иргэдийн нэгдсэн судалгааг авч нэгтгэхэд ирэх онуудад тэтгэвэр тогтоолгох иргэдийн тоо тогтворжих хандлагатай байна. | | |
| 5 | | Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль 2023.07.07 | Тайлант хугацаанд тахир дутуугийн болон тэжээгчээ алдсан 386 тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 2.2 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 33 иргэний тэтгэмжид 39.4 сая төгрөг, хиймэл эрхтэн, протез олгогдоогүй, нөхөн сэргээх зардалд 459 даатгуулагчид 345.6 сая төгрөгийн зардал тус тус зарцуулсан байна. | | |
| | | | | | |
| 2. Монгол улсын Засгийн газрын тогтоол | | | | | |
| 1 | №415 | Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай 2023.11.29 | “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээ тогтоох тухай” Засгийн газрын 2017 оны №251 тогтоолыг хүчингүй болгосон бөгөөд Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн өөрчлөгдөж 660, 000 төгрөг болсонтой холбогдуулан 1383 аж ахуйн нэгжид мэдээлэл хүргэн ажилласан. | | |
| 2 | №416 | Журам шинэчлэн батлах тухай 2023.11.29 | 1995 оноос өмнө хугацаат цэргийн алба хаасан 62 даатгуулагчийн алба хаасан хугацааг алба хаасан хугацааг шимтгэл төлсөн жилд, 10 дээш жил НДШ төлсөн 432 эхийн | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | төрүүлсэн болон үрчилж авсан хүүхэд бүрийн тоогоор 1 жил 06 сарыг нэмэгдүүлэн шимтгэл төлсөн жилд ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 35 иргэний ХЧА-аа алдсан байсан хугацааг тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн жилд тооцон тус тус тэтгэвэр тогтоосон. | | |
| 3 | №422 | Журам батлах тухай<br>2023.11.29 | “Үйлдвэрлэлийн осол, мэргэжилээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргэлтийн зардалын төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийн олгох, санхүүжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж 7 хоног бүрийн Лхагва гаригт Эрдэнэт сувилал цогцолборын эмч нарын зөвлөгөөнөөр орж сувилалд амрах шийдвэр авсан иргэн /даатгуулагчд/-ын амрах эрхийн бичгийг олгож, хаана амрах, амраад ямар бичиг баримт бүрдүүлэх талаар тогтмол заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.<br>Мөн иргэн /даатгуулагчид/-ын сувилалд амарсан жагсаалтыг тогтмол хянаж давхардал гаргахаас сэргийлж байна. | | |
| 4 | №438 | Журам батлах тухай<br>2023.12.13 | “Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам”-ын дагуу 5846 даатгуулагчид үйлчилгээ үзүүлж ажилласан. | | |
| 5 | №439 | Журам батлах тухай<br>2023.12.13 | “Үйлдвэрлэлийн осол, мэргэжилээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр тэтгэмж олгох журам”-ын дагуу 678 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласан. | | |
| 6 | №450 | Журам батлах тухай<br>2023.12.20 | “Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам”-ын дагуу 693 иргэнд шинээр, 265 иргэнд өөрчлөн тогтоолтоор тэтгэвэр олгосон. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | №83 | Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолын дагуу Тус газрын Төрийн Захиргааны 15 албан хаагчид 101,120,104 сая төгрөгийн урамшуулал олгож ажилласан. | | |
| 8 | №471 | Жагсаалт журам батлах тухай 2023.12.27 | Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 471 дүгээр тогтоолын дагуу "Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг хувь хэмжээг зөв тооцож нийгмийн даатгалын шимтгэл тооцох сургалтыг зохион байгуулж 1383 аж ахуйн нэгжид зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан. | | |
| 9 | №448 | Дүрэм батлах тухай 2023.12.13 | Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 446 дугаар тогтоолоор батлагдсан эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрмийг НДГ-ын дэргэдэх ЭММЗ-ийн бүрэлдхүүнд танилцуулж гишүүдийн 1 удаа сургалт орж, 7 хоног бүрийн Пүрэв гаригт хуралддаг ЭММЗ-ийн хуралд уг дүрмийг мөрдөн ажиллаж байна. | | |
| 10 | №84 | "Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай" 2024.02.28 | Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад Бичиг хэргийн ажилтан, архивын ажилтан ТҮМ болсон тул дээрхи албан хаагчдын цалинг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс дээрх шинэчилсэн тогтоолын дагуу олгож эхэлсэн. | | |
| 11 | №128 | "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2024.03.27 | Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны А/18 тоот тушаалаар 2024.04.01-ний өдрөөс албан хаагчдын үндсэн цалинг шинэ тогтоолын дагуу олгож эхэлсэн. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | №469 | “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм” Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм батлах тухай | Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Стандартын комисс нь МУ-ын Засгийн газрын 2023 оны 469 дүгээр тогтоолоор баталсан Нийгмийн даатгалын байгууллагын дүрэмээр 1 удаа сургалт орж 32 албан хаагчийг хамруулсан, мөн Нийгмийн даатгалын улсын байцаагчийн дүрмийг ажилтан албан хаагчдын мэдээллийн цагаар мэдээллэл хүргэж ажилласан бөгөөд 469 дүгээр тогтоолоор баталсан уг дүрмийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |
| 13 | №362 | Дүрэм батлах тухай 2023.09.26 | Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 362 дугаар тогтоооор “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм”-г шинэчлэн баталсан. Дүрмийн 2.1-ийн дагуу салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр НДЕГ-ын даргын 01/187 дугаар тушаалаар 9 гишүүн, нарийн бичгийн дарыг зөвшөөрсөн. Зөвлөлд 5 удаагийн хурлаар 16 иргэний өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн. | | |
| 14 | №10 | Итгэлцүүр тогтоох тухай 2024.01.10 | 2024.01.01-ний өдрөөс эхлэн Хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг 6.600.000 төгрөгтэй, сайн дураар даатгуулагчийн хувьд 4.620.000 төгрөгтэй тэнцүү байхаар тус тус тооцож НДШ-ийг авч байна. | | |
| 15 | № 187 | Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2022.05. 11 | 2024 оны байдлаар 11-11 төвөөр дамжуулан 13 иргэний өргөдөл хүсэлт ирж тухай бүр 100% шийдвэрлэн иргэнд хариу өгч ажилласан. | | |
| *Хэсгийн дундаж хувь: 100%* | | | | | |
| 3.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | |
| 1 | 22 | МУ-ын Засгийн газрын 2024.06.06-ны өдрийн 22 дугаар хуралдааны тэмдэглэл | Орхон аймгийн Шинэ хоршоо хөдөлгөөний сургагч багш нартай хамтран НД-ын хамрагдалт болон шинээр үүсгэн байгуулсан хоршоог Нийгмийн даатгалд бүртгүүлэх, | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нийгмийн даатгалын ерөнхий газарт мэдээлэл хүргэн ажилласан. Шинээр үүссэн хоршоодын талаарх мэдээллийг авахаар Баян-Өндөр сумын Тамгын газарт хүсэлт хүргүүлээд байна. | | |
| 2 | 15 | МУ-ын Засгийн газрын 2024.04.17-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Нийгмийн даатгалын сангийн 159 болон байгууллагын 171 шилэн дансны нийт 330 мэдээллээс хуулийн хугацаанд хоцроогоогүй бүрэн оруулсан нийт 133 мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгаж үнэн зөв байршуулж, хэрэглэгч, ажил олгогч, иргэд, олон нийтэд нээлттэй танилцах боломжийг бүрдүүлж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | | |
| *Хэсгийн дундаж хувь: 100%* | | | | | |
| 4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал | | | | | |
| 1 | А/199 | Журам батлах тухай<br>2023.12.25 | Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагыг барагдуулах ажлын хүрээнд Монгол улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам” дагуу шат дараалласан арга хэмжээг авч ажиллаж байна.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/64 тоот “Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэх тухай” тушаалын дагуу үны эхний шимтгэлийн авлагыг 30-аас доошгүй хувиар бууруулах гэсний дагуу өмнөх оны жилийн эцэс, 2024 оны шимтгэлийн авлага 596 ААНБ-ын 5,576,596.43 мянган төгрөгийн авлагаас 2,068,203.88 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан ба 37.09 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нийгмийн даатгалын шимтгэлт төлөлтийн тайланд журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж 1367 аж ахуйн нэгжийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хяналт тавьж ажиллаж байна. | | |
| 2 | А/53 | Дотоод аудитын тайлан батлах, ажил эрчимжүүлэх тухай<br>2024.03.22 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Нийгмийн даатгалын сангийн 159 болон байгууллагын 171 шилэн дансны нийт 330 мэдээллээс хуулийн хугацаанд хоцроогоогүй бүрэн оруулсан нийт 133 мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгаж үнэн зөв байршуулж, хэрэглэгч, ажил олгогч, иргэд, олон нийтэд нээлттэй танилцах боломжийг бүрдүүлж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | | |
| 3 | А/80 | Мэргэшлийн зэрэг олгох тухай<br>2024.04.18 | Мэргэшлийн зэрэг олгох тухай А/80 тоот тушаалаар тус газрын Тэргүүлэх мэргэшлийн зэрэг-9, | | |
| 4 | А/87 | Тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай<br>2024.04.23 | “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжилтийн жагсаалтыг нийт байцаагч ажилтануудад танилцуулж хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг 7 аж ахуй нэгж байгууллагад албан тоот хүргүүлэн сургалт зохион байгуулж хамтран ажилласан. | | |
| 5 | А/44,<br>А/40 | Маягтын загвар аргачлал батлах тухай<br>2024.03.06 | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтуудыг зааврын дагуу бүртгэж хэвшсэн. | | |
| 6 | А/40 | Журам батлах тухай<br>2024.03.01 | Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан байцаагч ажилтануудад 2024.04.03-ны өдөр сургалт, мэдээлэл хийж 2024 онд Улсын байцаагчийн шалгалтад орох албан хаагчдын нэрсийн жагсаалт гаргаж ажиллалаа. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | А/441<br>А/192 | Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт батлах тухай<br>2023.12.15 | Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хамтарсан тушаалаар Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалтыг баталсан бөгөөд тушаалын хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн мөрдөн ажиллаж байна.<br>Шинэ жагсаалтаар иргэн /даатгуулагчид/-ын хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг нийт 31 ЭММЗ-ийн болон төв, орон нутгийн төрөлжсөн мэргэжлийн эмч мэргэжилтнүүдийн саналын үндсэн дээр өөрчлөгдсөн. | | |
| 8 | А/69<br>А/132 | Монгол улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчий газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг батлах тухай | Орхон аймагт Нийгмийн даатгалын шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон Дипломат төлөөлөгчий газрын ажилтан байхгүй байгаа хэдий ч ХНХ-ын сайдын тушаалыг дотоод сургалтын цагаар байцаагч ажилтануудад мэдээлэл хүргэж ажилласан. | | |
| 9 | А/143<br>А/376 | Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортепедийн жишиг үнэ батлах тухай<br>2023.10.26 | Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалийн сангаас олгох протез, ортепедийн жишиг үнэ батлах тухай тушаалыг НДГ-ын тэтгэмжийн болон үйлчилгээний байцаагч нарт таниулах дотоод сургалтаар орж, иргэн /даатгуулагчид/-аас анхан шатны материал хүлээж авахдаа таниулж тайлбарлан ажиллаж байна.<br>2024 оны эхний хагас жилийн байдлаар 172 иргэн /даатгуулагчид/-д эрх үүсээгүй эрхийн бичгийг хяналтын дагуу олгосон байна. | | |
| 10 | А/177<br>А/433 | Журам маягтын загвар батлах тухай<br>2023.12.07 | Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | өдрийн хамтарсан Эмнэлгийн хуудас олгох журам А/177, А/433 тоот тушаалын хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба ӨЭМТ-ийн 9, хувийн хэвшлийн 13 эмнэлэг, БОЭТ, Эрдэнэт сувилал, Эрдэнэт медикал Жаргалант сумын эмнэлэгийн эмч, мэргэжилтэнүүдэд цахимаар сургалт зохион байгууллаа. Мөн журмын талаархи зөвлөгөө мэдээллийг НДГ-ын лавлах утас 75776699 болон цахимаар тогтмол өгч байна. | | |
| 11 | А/136 | Тэтгэвэр тогтоолгох, үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай 2023.10.05 | Тэтгэвэр тогтоолгох, үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалинг үндэслэн 17 тэтгэвэр авагчийн тэтгэврийг бодсон. | | |
| 12 | А/200 | Журам гэрээний загвар батлах тухай 2023.12.25 | Энгийн болон малчин, даатгуулагч эх 5330 даатгуулагчийн сайн дурын даатгалын гэрээг байгуулж батлагдсан гэрээг баримтжуулан журмын хэрэгжилтийг ханган ажилласан байна. | | |
| 13 | А/221 | Жагсаалт, журам батлах тухай | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/221 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/221 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт-р баталсан журмын дагуу 2004 оны 77 тушаал хэрэгжиж байх үеийн ажил мэргэжил, албан тушаалыг журмын дагуу нөхцлийн жилийг тооцож, эргэлзээтэй 7 иргэний хүсэлтийг Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүнд нөхцлөөр шийдвэрлэж тэтгэвэр тогтоосон. | | |
| *Хэсгийн дундаж хувь: 100* | | | | | |

| 5.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1. | №08 | Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай 2023.12.04 | 2024 онд нас барсан 244 даатгуулачгийн ар гэрт 448 сая төгрөгийн тэтгэмж олгосон. Амьгүй донор болсон тохиолдол манай аймагт гараагүй. | | |
| 2. | №9 | Шимтгэлийн хэмжээ тогтоох тухай 2023.12.04 | БНСУлсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Монгол улсын иргэдийн тэтгэврийн даатгалд даатгуулах шимтгэлийн хэмжээг 50.000 вон болгосон тухай тогтоолыг байцаагч ажилтануудад хүргэж ажилласан. | | |
| 3 | №10 | Сэргээн засах болон сувилалын тусламж үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжилээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай 2023.12.04 | Сэргээн засах болон сувилалын тусламж үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжилээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг 70.000 төгрөгөөр тооцож 277 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. | | |
| 4 | №11 | Даатгуулагчид тусламж үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувилалыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх тусламж үйлчилгээний журамд хяналт тавих журам 2023.12.04 | Даатгуулагчид тусламж үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувилалыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх тусламж үйлчилгээний журамд хяналт тавих журам нь өнөөдрийн байдлаар хэвийн хэрэгжиж байгаа ба шинэчилсэн журамд санал авах үйл ажиллагаа явагдаж байна. Мөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн Сэргээн засах болон сувилалын тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох тухай 10 дугаар тогтоолын 1 дүгээр заалтын дагуу ор хоногийн төлбөрийн зөрүүг тооцох ажлыг зохион байгуулж байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | №15 | Нэрийн дансны 2023 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай 2023.12.21 | Нэрийн дансны 2023 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай тогтоолыг мэдээллийн цагаар байцаагч ажилтануудад танилцуулж ажилласан. | | |
| 6 | №20 | Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл авах тухай 2023.12.21 | Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл авах тухай тогтоолыг мэдээллийн цагаар байцаагч ажилтануудад танилцуулж ажилласан. | | |
| 7 | №01 | Журам батлах тухай 2024.03.05 | 1383 ажил олгогч байгууллагын 26597 даатгуулагчийн Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдэлийг тооцохтой холбогдсон журмыг судлан хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |
| *Хэсгийн дундаж хувь:* | | | | | |
| 6.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал | | | | | |
| 1 | А/02 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарь батлах тухай 2024.01.04 | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө – 178.5 тэрбум, зардал 222.1 тэрбум төгрөг байна. | | |
| 2 | А/03 | Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарь батлах тухай 2024.01.04 | Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагааны зардлыг хуваарийн дагуу зарцуулсан бөгөөд Эхний сараас цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал ангилалд өр үүссэн үзүүлэлттэй байна. | | |
| 3 | А/15 | Төлөвлөгөө батлах тухай 2024.01.25 | 2024 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дураар даатгуулагчийн тооны төлөвлөгөөны биелэлтийг ханган Нийгмийн даатгал төлдөггүй тодорхой ажил хөдөлмөр эрхлэдэггүй иргэн, малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах, шинэчлэн батлагдсан төлөвлөгөөг биелүүлэхийг сар бүр гаргаж сарын мэдээ тайланг хүргүүлэн ажиллалаа.<br>НДСангийн сарын мэдээ 5 удаа гаргасан байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | А/43 | Даатгуулагчийн төрлийн код нэмж батлах тухай | Засгийн газрын 2023 оны 469 дүгээр тогтоолоор баталсан ”Нийгмийн даатгалын байгууллагын дурэм”-ийн 3.2.3 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны ”Маягтын загвар, аргачлал батлах тухай” А44/А/40 дүгээр хамтарсан тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж аж ахуйн нэгж байгууллага, иргэд даатгуулагчид мэдээлэл түгээн ажиллаж байна | | |
| 5 | А/49 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хувиарт өөрчлөлт оруулах тухай 2024.04.08 | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө – 178.5 тэрбум байхаас зардал 222.1 тэрбум төгрөг байна. | | |
| 6 | А/47 | Үйл ажиллагааны зардалын 2024 оны төсвийн хувиарт өөрчлөлт оруулах тухай 2024.04.08 | 2024 оны эхний улирлын байдлаар батлагдсан төсөв 301,315,300 төгрөг байсан ба гүйцэтгэл 271,059,196.07 төгрөг байна. Үйл ажиллагааны зардлыг хуваарийн дагуу зарцуулсан. Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын ангилалд өр нэмэгдсэн байна. | | |
| 7 | А/67 | Үйл ажиллагааны урсгал зардалын 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай 2024.05.07 | Хагас жилийн байдлаар батлагдсан төсөв 773,119,000 төгрөг байсан ба гүйцэтгэл 704,977,100.96 төгрөг байна. Үйл ажиллагааны зардлыг хуваарийн дагуу зарцуулсан. Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал зардлын ангилалд өр нэмэгдсэн. НДЕГ-т мэдэгдсэн. | | |
| 8 | А/64 | Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах ажил эрчимжүүлэх тухай 2024.05.02 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/64 тоот “Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэх тухай” тушаалын дагуу үны эхний шимтгэлийн авлагыг 30-аас доошгүй хувиар буруулах гэсний дагуу өмнөх оны жилийн эцэс, 2024 оны шимтгэлийн авлага 596 ААНБ-ын 5,576,596.43 мянган төгрөгийн авлагаас 2,068,203.88 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан ба 37.09 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | **<u>Уулзалтаар</u>** – 284 ААНБ-ын 530.7 сая төгрөгийн өр авлагыг талаар уулзалт хийж холбогдох хариуцлага болон дараагийн авах арга хэмжээг танилцуулсан.<br>**<u>Хуваарь гаргаж</u>** – 3 ААНБ-тай 973,924.72 мянган төгрөгийн авлага барагдуулах гэрээ байгуулан тус ААНБ-ууд 374,662.06 мянган төгрөгийг санд төлж гэрээний биелэлтээ ханган ажиллаж байна.<br>**<u>Данс хаасан</u>** – 48 ААНБ-ын 514,685.90 мянган төгрөгийн авлагатай холбоотойгоор байгууллагын харилцах данс хааснаар 4 ААНБ-ын 81,870.78 мянган төгрөгийн авлагыг бууруулан ажилласан байна.<br>**<u>Албан шаардлага</u>** - 9 ААНБ-ын 40,338.31 мянган төгрөгийн авлагад шаардлага хүргүүлснээр 2 ААНБ-ын 2,139.20 мянган төгрөгийн авлага барагдуулсан байна.<br>**<u>Прокурорт шилжүүлсэн</u>** – 2 ААНБ-ын 93,877.30 мянган төгрөгийн авлагад Зөрчлийн тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлүүлэхээр материал хүргүүлсэн байна. | | |
| 9 | А/83 | Маягтын загвар батлах тухай<br>2024.05.21 | Өртэй байгууллагын банкин дахь дансны зардалын гүйлгээг түр зогсоож шимтгэл алданги төлүүлэх "мэдэгдэл"-ийн маягт, дансны гүйлгээ нээх зөвшөөрлийн дагуу банкуудтай хамтран ажиллаж өр авлага барагдуулан ажиллаж байна. | | |
| 10 | А/80 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай<br>2024.05.21 | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө – 178.5 тэрбум, зардал 222.1 тэрбум төгрөг байна. | | |
| 11 | А/51 | Аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц орон тоог батлах тухай<br>2024.04.08 | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2024 оны А/51 тушаалаар тус газрын орон тоог Төрийн захиргааны албан хаагч 34, Төрийн үйлчилгээний албан хаагч 6 нийт 40 орон тоотойгоор баталсан. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | А/20 | Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай 2024.02.08 | 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийг бэлтгэж, цахим хуудсанд байршуулах, хянах төвлөгөө"-г газрын даргаар батлуулж, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |
| 13 | А/72 | Журам аргачлал батлах тухай | Төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, төсвийн нарийвчилсан хуваар батлах, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулахад баримтлах журмыг хэрэгжүүлэн ажиллаж, Төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах ажлын хэсгийг газрын даргын 2024 оны А/26 тоот тушаалаар байгуулан ажиллаж 2025 оны төсөл, 2026-2027 онуудын төсөөллийг журмын дагуу боловсруулж заасан хугацаанд дээд газарт хүргүүлсэн. | | |
| 14 | А/94 | Аудитын акт, албан шаардлага зөвлөмж хэрэгжүүлжх тухай 2024.05.31 | Аудитын дүгнэлтийн дагуу 2 актыг төлбөрийг бүрэн барагдуулж, 3 зөвлөмжийг биелүүлэн ажилласан. | | |
| 15 | А/61 | 2024 оныг Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай 2024.04.24 | Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх болзолт уралдааныг байцаагч ажилтнуудад танилцуулан, хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэн<br>✓ Нээлттэй хаалганы өдөрлөгийг Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран 9 чиглэлд 2 удаа 111 иргэд, даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн;<br>✓ Ажил олгогч, даатгуулагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид чиглэсэн 16 удаагийн сургалтад 597 иргэдэд мэдээлэл хүргэсэн;<br>✓ Явуулын үйлчилгээгээр 11 чиглэлд 259 малчин иргэдэд мэдээлэл хүргэсэн;<br>✓ Нийгмийн даатгалд хамрагдаагүй 94 ААНБ бүртгэж 124 албан журмын даатгуулагчийг хамруулсан;<br>✓ Шинээр сайн дуурын даатгалд 184 иргэн хамруулсан; | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ✓ Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах 48 удаагийн сургалтыг зохион байгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллалаа.ажилласан байна. | | |
| 16 | А/79 | Болзолт уралдаан зарлах тухай 2024.05.17 | Баян-Өндөр сумын ЗДТГ-тай хамтран ажиллах төлөвлөгөө гарган болзолт уралдааны удирдамжийг байцаагч ажилтнуудад танилцуулан хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. | | |
| 17 | А/75 | Урамшуулал олгох тухай | 2023 оны ажлын үзүүлэлтээр аудитын өөрчлөлтгүй дүгнэлт авч ажилласан тул 100% урамшуулал буюу ахлах нягтлан бодогчийн сарын үндсэн цалин 1,597,000 төгрөгийг ахлах нягтлан бодогч Ү.Мягмарсүрэнд олгосон. | | |
| 18 | А/190 | Журам батлах тухай 2023.12.27 | Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид, бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх, хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэх журмыг байцаагч ажилтнуудад танилцуулан арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар шинээр нийгмийн даатгалд хамрагдаагүй 94 ААНБ бүртгэж 124 албан журмын даатгуулагчийг хамруулсан. Шинээр сайн дурын даатгалд 184 иргэн хамруулсан. Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах 48 удаагийн сургалтыг зохион байгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан байна. | | |
| Хэсгийн дундаж хувь *100%* | | | | | |
| Нийт дундаж хувь:100 | | | | | |

Биелэлтийн товчоо

| Д/д | Зорилт арга хэмжээ | Аргаа хэмжээний тоо | Үүнээс | | | | Хэрэгжилтийн тооцох хугацаа болоогүй | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100% биелсэн | Хэрэгжих шатандаа | | | | |
| | | | | 70% | 30% | 0% | | |
| 1. | Монгол улсын хууль | 5 | 5 | | | | | |
| 2. | Засгийн газрын тогтоол | 15 | 15 | | | | | 100% |
| 3. | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 2 | 2 | | | | | 100% |
| 4. | ХНХЯ-ны сайдын тушаал | 13 | 13 | | | | | |
| 5. | НД-ын ҮЗ-ын тогтоол | 7 | 7 | | | | | 100% |
| 6. | НДЕГ-ын даргын тушаал | 18 | 18 | | | | | 100% |
| **Нийт 100%** | | | | | | | | |

ХЯНАСАН:
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРМАНДАХ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН Д.ИДЭРЖАВХЛАН